

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-17

1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/ 6-7

2.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай болон Хувийн тэтгэврийн тухай хуулиудын нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 5 гишүүн 2020.05.13-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/ 7-17

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
12 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 34 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Д.Өнөрболор, Ч.Ундрэм;
Чөлөөтэй: Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, С.Чинзориг;

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, А.Хонгорзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдсангүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай болон Хувийн тэтгэврийн тухай хуулиудын нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 5 гишүүн 2020.05.13-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын хэлтсийн дарга Н.Батболд, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Нинжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Т.Аубакир нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

1.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай болон Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

3.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

4.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

5.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

6.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

7.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 55 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 66.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 29 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 34 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Өнөөдөр Баагаагийн Баттөмөр гишүүн орон нутагт ажиллаж байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн мөн орон нутагт ажиллаж байна. Чинбатын Ундрам гишүүн мөн орон нутагт ажиллаж байна. Бусад гишүүд хүрэлцэн иржээ.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 5-ны өдөр өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хоёр суудал байна.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 12 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёр.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай, Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2021 оны 10 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 5 гишүүн, 2020 оны 5 сарын 13-ны өдөр

өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлнэ. Ийм хоёр асуудал байна.

Энэ хэлэлцэх асуудлууд дээр саналтай гишүүд байна уу. Ганхуяг гишүүн, Энхтүвшин гишүүн сая дарсан уу? Дараарай. Ганхуяг гишүүн дарсан уу? Ганхуяг гишүүнээр тасалъя. Ганхуяг гишүүний нэрийг оруулаарай. Энхтүвшин гишүүн саналаа хэлье, микрофоныг нь нээнэ үү.

Т.Энхтүвшин: Энэ 12 дугаар сард хэлэлцэх энэ цаглавар орж ирж байна. Бид нар эдийн засгаа өсгөе гээд ярьж байсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиа хэзээ оруулж ирэх юм бэ. Энийг оруулж болохгүй юу? Ялангуяа тэр газартай холбоотой асуудал нь хасагдсан шүү дээ. Тийм учраас энэ гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, 2024 онд гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирэх талаар бас анхаарвал яасан юм бэ? Тийм учраас энэ асуудлыг бас хэлэлцэх ажлын төлөвлөгөөнд бас тусгаж өгөөч гэдгийг.

Хоёр дахь асуудал энэ Ашигт малтмалын тухай хууль оруулж ирэх ёстой болов уу гэсэн ийм бодолтой байж байна. Ер нь ард ирэгдэд хамгийн их хүлээгдэж байгаа ажил бол энэ Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтүүд байж байгаа юм. Тийм учраас энэ Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтийг бас оруулж ирвэл яасан юм бэ гэдэг ийм хоёр саналыг тавьж байна. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн юу шүү дээ Хөрөнгө оруулалтын хууль чинь Байнгын хороогоороо ороод, одоо чуулганаар оруулж хэлэлцэх эсэх нь явагдах ёстой, одоо хүлээгдэж байгаа. Ингээд чуулганаар хэлэлцэх эсэх нь хэрвээ дэмжигдээд ирэх юм бол манай Байнгын хороон дээр орж ирээд, бид нар чинь ажлын хэсгээ байгуулаад ажиллаад явна.

Ашигт малтмалын хууль, энэ төсөл бол Засгийн газар дээр хийгдсэн

явж байсан. Өнөөдөр ерөөсөө өргөн баригдаагүй байгаа шүү дээ. Засгийн газар өргөн бариагүй, одоо хүлээгдэж байна. Энэ хоёр хуулийн хувьд яг одоо байгаа статус нь ийм байдалтай байна.

Ганхуяг гишүүн саналаа хэлье. Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

Х.Ганхуяг: Сайн байцгаана уу. Энэ 12 дугаар сард уг нь хувийн хэвшлийг дэмжсэн хуулиуд уг нь ярилцъя гэж бүлэг дээр ярьж байсан. Хувийн хэвшилтэй холбоотой ерөөсөө нэг ч хууль алга Банк бусын хуулиас гадна. Өнөөдөр нүүрсний сонсгол хийгээд байдаг, авлигал гээд л 30 жилийн авлигал яриад байдаг. Ер нь гол асуудал маань өөрөө эдийн засгийн хуулиуд шүү дээ. Зөвшөөрлийн хуультай адилхан тэр хуулиудаар эдийн засгийн хуулиудаа багц, суурь хуулиудаа оролдохгүйгээр бид нар авлигыг багасгах ямар ч боломж байхгүй шүү дээ. Нөгөө газрын багц хууль хааччихсан юм бэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай компанийн аж ахуйн нэгжийн тухай хууль хааччихсан юм бэ? Яагаад энэ асуудлууд чинь ерөөсөө хэлэлцэгддэггүй юм бэ? Ер нь энэ Эрдэнэс Тавантолгойн хулгай, энэ нүүрсний хулгай чинь бүгдээрээ л ТӨК-даа л хийгдсэн хулгай шүү дээ. Ингээд нэг хууль өргөн барьсан болдог, хэн нь ахалж байгаа нь мэдэгдэхгүй нөгөө хууль нь алга болчихдог. Энэ чинь хугацаа эд нар зааж барьдаггүй юм уу? Энэ саяын Хөрөнгө оруулалтын хуулиас гадна энэ чинь бид нар Хөрөнгө оруулалтын хууль нь байхгүй байна. Энэ бид нарын өргөн барьсан Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд шинээр байгуулахыг хориглох тухай, менежментийг нь сайжруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслөөс өөр юм алга байна л даа энэ.

Тэгэхээр энэ Байнгын хороо маань уг нь энэ 12 сард их л завгүй, их л олон хуулиуд хэлэлцэх юм болов уу гэсэн чинь юу ч л байхгүй байна л даа. Өргөн барьсан гурван төслийнх нь хоёр дээр нь

би ажилласан юм байна. Санаачилж өргөн барьсан юм байна.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүний асууж байгаа хуулиуд чинь газрын багц хуулиуд бол угаасаа Их Хурлаас Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороогоор явъя гээд шийдчихсэн. Одоо энэ дээрээ, энэ Байнгын хороон дээрээ байгаа байх.

Төрийн өмчийн болон төрийн өмчийн компаниудын тухай хууль хоёулаа хоёр ажлын хэсгийг Энхбаяр гишүүн дээр, Энхбаяр гишүүн ажлын хэсгийг ахалж байгаа. Одоо ажиллаж байгаа. Тэгэхлээр одоо энэ хяналтын сонсгол явуулаад завгүй байгаа байх. Ер нь ойрын үед бэлэн болж байгаа юм ярьсан. Ажлын хэсэг сайн ажиллаж байгаа гэсэн. Удахгүй орж ирэх байх, орж ирж хэлэлцэх байх.

Ингээд өөр саналтай гишүүд байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа орёе.

Хэлэлцэх асуудал нэг, 2023 оны 12 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Монгол Улсын Их Хурлын тухай чуулганы 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 199 дүгээр захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх

асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаврыг хавсралтаар баталсугай.

2.Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлуудын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3.Энэ тогтоолын биелэлтийг хангаж, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар Д.Энхбатад үүрэг болгосугай гэсэн тогтоолын төсөл байна.

Төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Ирцэд та ороод, ороогүй байгаа юу. Одоо дөнгөж цаглавраа батлаадахъя. Та дөнгөж жоохон.

Тэгэхдээ гишүүд бас санал, асуулт асуух байх шүү Булгаа сайд аа. Та бас ажлынхаа хэсгийг бэлэн байлгаж байна шүү.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Санал хураалт явуулж эхэлье.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 12 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Баярлалаа Доржханд гишүүн ээ, хүүе ээ уначихлаа шүү дээ баярлалаа гэсэн чинь. Хэнийх ажилласангүй вэ. Хүүе ээ би дарсан шүү дээ. Энэ төхөөрөмж ямар сонин юм бэ. Уучлаарай энэ миний төхөөрөмж ажилласангүй. Саяын хураасан санал хураалтыг хүчингүй

болгоё. Дахин санал хураалт явуулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя. Хүчингүй болгоё гэсэн.

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж саяын хураасан санал хүчингүй боллоо. Ийм учраас дахин түрүүчийн саналыг дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 54.5 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт болж дууслаа.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 12 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. Дараагийнхаа асуудалд орёё.

14.54 цаг

Хэлэлцэх асуудал хоёр. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай, Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Х.Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Б.Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Н.Батболд Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Н.Нинжин Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дүгээр зүйлийг баримтлан хуулийн төслүүдийг хэлэлцье.

1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ганхуяг гишүүн, Аубакир гишүүн. Аубакир гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн асуултаа асууна уу.

Х.Ганхуяг: *Хувийн тэтгэврийн сан байгуулах асуудлыг дэмжиж байна. Өнөөдрийг хүртэл явж ирсэн энэ сангууд нь ямар учиртай, ямар зохицуулалттай, яаж яваад байгаа тодорхой хариу авчихмаар байна.*

Хоёрдугаарт, энэ хуулиар ер нь ямар ямар өөрчлөлт хийх гэж байгаа юм, юу зорьж байгаа гэдгийг бас нэг сонсчихмоор байна. Ер нь энэ нийгмийн даатгалын багц хуулиа ер нь эргэж харах уу энэ ойрын үед? Энэ чинь ерөөсөө яг татвар шиг болчихоод байна шүү дээ. Бас энэ нэг эсэргүүцээд байсан шалтгааны нэг нь ч тэр л дээ. Иргэд төлөөд л байдаг, тэгээд л ерөөсөө яг татвар шиг аваад л байдаг. Тэгээд хэдэн төгрөг хуримтлагдаж байгаа нь бодит биш. Дараа нь зүгээр тоо байдаг. Өөрөө хүн хаашаа, юу хийхээ шийдэж чаддаггүй. Өмнөөс нь дарга нар шийддэг. Мөнгийг нь хуримтлуулж аваад, тэгээд банканд хадгаламжид хийгээд алддаг. Ерөөсөө л болж байгаа процесс энэ л дээ. Иргэд бол нийгмийн даатгалын энэ юунд ч ерөөсөө итгэхээ больчихоод байна л даа.

Саяын энэ санал хураалтаар яагаад тэр 100 мянган иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулъя гэж санал өгсөн бэ гэхээр ерөөсөө хариулт нь энэ байхгүй юу. Энэ тал дээр ер нь ямар нэгэн өөрчлөлт ер нь бодож байгаа юм байна уу? Нэг юм ярихаар боломжгүй л гэнэ, нэг юм ярихаар тийм боломжгүй л гэнэ гээд. Ерөөсөө ямар ч өөрчлөлт ордоггүй. Хамгийн хоцрогдсон нийгмийн даатгалын системтэй. Уг нь өргөн бариад сая нийгмийн даатгалын багц хууль батлагдаад нэлээн өөрчлөлт орох болов уу гэсэн манай Байнгын хороогоор орохгүйгээр яваад, өөр газар хэлэлцэгдээд л явчихсан л даа. Би энэ асуултууд дээр

яг тодорхой хариулт авчихмаар байна. Бид нар хугацаатай байдаг. Та нар яг хариулахаар дандаа тойруулаад л хариулаад эхэлдэг шүү дээ тээ. Яг сая би 4 асуулт асуулаа, 4 асуулт дээр яг тодорхой хариулт өгөөдхөөрэй.

Ц.Цэрэнпунцаг: *Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа сайд хариулъя. Булгантуяа сайдын микрофоныг нээе дээ.*

Х.Булгантуяа: *Одоо манай улсын хувьд тусгай зөвшөөрөл бүхий 1 урт хугацааны даатгагч, ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүй авахгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 аж ахуйн нэгж байгаа. Ерөнхийдөө энэ нийтдээ 4 аж ахуйн нэгжийн хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг явуулж байна гэсэн үг. Хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс бас энд эрсдэл үүсэх магадлалтай.*

Тийм учраас энэ хууль, эрх зүйн орчныг нээж өгөх, аж ахуйн нэгжүүдээс ажил олгогчдоос ч гэсэндээ ийм бүтээгдэхүүн өөрөө хүсээд байгаа юм. Ялангуяа үүнийг ажил олгогч ажилтнаа бас татах, урт хугацаанд тогтвор, суурьшилтай ажиллуулах ийм том хөшүүрэг болно гэж үзэж байгаа. Тийм учраас хувийн тэтгэврийн санг аж ахуйн нэгжүүд хуулийн зохицуулалтыг нэн яаралтай гаргаж өгөөч гэдэг ийм хүсэлтийг тавьж байгаа.

Нийгмийн даатгалын багц хууль бол сая 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан. Энэ хууль дээр нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ багасаагүй. Гол нь хүмүүсээс, иргэдээс бас тавьж байгаа хэд хэдэн асуултууд нэгдүгээрт тэтгэвэрт гарсны дараа шимтгэл төлөгч надад ямар давуу байдал үүсэх юм. Яг таны хэлж байгаа юм үнэн.

Тэгэхээр шимтгэл төлөгчийн одоогоор тэтгэврийн шимтгэлийн 17 хувь гэхэд тэр чигээрээ бид нар эв санааны нэгдлийн зарчмаар 1994 онд одоогийн нийгмийн даатгалын 23 оны 12 сарын 31 хүртэл хэрэгжиж байгаа

нийгмийн даатгалын одоогийн системээр шимтгэл төлж байгаа, бид нарын шимтгэлийг хуримтлуулаад өнөөдрийн тэтгэвэр авагчдын тэтгэврийг тавьж байгаа. 1.3 сая хүн шимтгэл төлөөд, 500 мянган хүн өнөөдөр тэтгэвэр авч байна. Ирэх оноос авхуулаад бид нар энэ шимтгэлийг 2 хувь ингээд эдийн засгийн боломж бололцоогоороо мөнгөжүүлээд өөрийн чинь нэрийн данс дээр байршина. Үүгээрээ ахиад ипотекийн орон сууц, эрүүл мэнд, боловсрол гэх мэтчилэн үйлчилгээнд зарцуулдаг болох энэ эрхийг нь бид нар нээж өгөхөөр ажиллаж байна.

Хоёрдугаарт ахиад дээрээс нь нэмээд бид нар шимтгэлийг нь хуримтлуулаад байхад бид нарын мөнгө энд тэнд очоод, банканд очоод алга болоод байдаг үүнийгээ сайжруулаач гэсэн. Үүнтэй холбоотойгоор бид нар энэ менежмент, зохицуулалт дээр нь бид нар бас сайжруулах хэд хэдэн хуулийн заалтыг оруулж өгсөн. Энэ 2 хувь түрүүний яг хэлсэнчлэн мөнгө чинь байршиж байгаа 2 хувь бол 2030 он хүртэл үүнийг байршуулаад үнэ нь өвлөгддөг ийм хууль, эрх зүйн орчнуудыг бид нар бий болгож байна. Нийгмийн даатгалын шимтгэлийг буулгаж болно. Тэгэх юм бол үүний нөхөөсийг улсын төсвөөс л төлнө.

Яагаад гэвэл бид нар хүмүүсийн тэтгэврийг багасгаж чадахгүй. Тэгэхээр та яг л нэг кармагаас, нөгөө карма руу бид нар татварынх нь тэгвэл манай улсын татварын орлого л онцгой сайн нэмэгддэггүй юм бол энэ буцаад л улсын төсвөөс нийгмийн даатгалын сан руу орно гэсэн үг.

Шимтгэл төлөхгүй байх юм бол халамж авагчдын тоо л нөгөө талдаа өсдөг. Монголын хуулийн дагуу хэрвээ тэтгэврийн насанд хүрээд шимтгэл төлөөгүй дор хаяж 10 жил төлж тэтгэврийн сангаас тэтгэвэр авах эрх нь үүсэхгүй бол халамжаас халамжийн тэтгэвэр авдаг. Тэгэхээр бид нар аль болохоор халамжаас татгалзъя гэх юм

бол шимтгэл төлөлтийг бид нар нийгмийн даатгалын шимтгэл төлж ахмад насандаа дунджаар эмэгтэй хүн бол 22 жил, эрэгтэй хүн 16 жил тэтгэвэр авдаг. Дунджаар Монгол дундаж хүн 25 жил шимтгэл төлдөг. Тэтгэвэрт гарч байгаа хүмүүс нь 45 хувь нь ямар нэгэн хөнгөлөлттэй нөхцөлөөр гардаг. Олон хүүхэд гаргахад гаргасан гээд л. Жишээлбэл 1 хүүхэд гаргахад 1.5 жил тэтгэврийн наснаас наашаа татдаг, хүнд хорттой нөхцөлд, уул уурхайд ажиллаж байгаа гэх мэтчилэн ийм байдлаар бас эрт тэтгэвэрт гарах, хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарах ийм байгаа. Тэгэхээр саяын энэ Улсын Их Хурлаас баталж өгсөн хуулийн дагуу 2024 оны 1 сарын 1-нээс ийм зохицуулалттайгаар явахаар байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Сая Ганхуяг гишүүний асуусан асуултад тодорхой дахиад ажлын хэсгээс нэмж бүр тодорхой хариулах хүмүүс байна уу ажлын хэсгийн? Тэр хамгийн гол нь энэ манай энэ Байнгын хорооны гишүүд байна шүү дээ мэдээлэл жоохон муутай байгаа. Хууль гэнэтхэн орж ирсэн тийм үү. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр байж байгаад. Тийм учраас яг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн үзэл санаа, одоо та нарын оруулж ирж байгаа энэ төсөл, үзэл санаа яг үндсэн гол ямар зарчмуудаар ялгаатай юм гэдгийг нь тодорхой хэлээдэх. Ажлын хэсгийн 5 номер хариулъя.

Б.Батжаргал: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Батжаргал. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл бол анхдагч хуулийн төсөл. Одоо мөрдөгдөж байгаа хууль байхгүй. Түрүүн Булгантуяа сайд хэлсэн одоо зах зээл дээр Үндэсний амьдралын даатгалын компани бол Даатгалын тухай хуулиар “Ард лайф” ХХК бол Компанийн тухай хуулиар, “Голомт” банкны тус сан бол Төрийн бус байгууллагын тухай хуулиар, “Хас” банкны дэргэдэх сан бол тухайлсан, бас зохицуулсан журмуудаар өөр өөр зохицуулалтаар явж байгааг нэг

болгож зохицуулах, одоо байгаа нэгэнт үүссэн зах зээлийг бас хамгаалах, энэ зах зээл дээр бас хамрагдсан иргэдийн буюу энэ гишүүний хөрөнгийг, эрх ашгийг хамгаалах зорилгоор боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан хууль байгаа юм гэдгийг хэлье.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүн тодруулж асуулт асууя.

Х.Ганхуяг: Би та нарт ганцхан л тоо хэлж өгье л дөө. Сайн дураараа даатгуулагч жилд 300 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлдөг. 30 жил төлөөд тэтгэврээ тогтоолгоход 10-аад сая төгрөгийн, 11 сая төгрөг хавьцаа нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа. Тэгээд авах тэтгэвр нь 550 мянган төгрөг.

Нөгөө талд нь өдөр, шөнөгүй ажиллаж байгаа, цалингаасаа 20-23 хувийн нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа иргэн 30 жил ажиллахад ойролцоогоор 160-170 сая төгрөг төлж байгаа улсад. Буцаагаад авдаг дэвтэр нь яг адилхан 550 мянган төгрөг. Энэ шударга уу, энэ шударга уу? Би зүгээр энэ дээр л хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хэн хариулах юм. Ажлын хэсгийн 5 номер хариулъя.

Б.Батжаргал: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хүрээнд асуулт асууж байна гэж ойлголоо. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн эрх үүсэх зохицуулалт нь 20 ба түүнээс дээш жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх, хуулиар тогтоосон насанд хүрсэн байх гэсэн ийм зохицуулалт, үндсэн хоёр шалгууртай. Энэ шалгуурт хүрэхийн тулд нийгмийн даатгалын хамралт нь одоо манай хуулиар буюу тогтоосноор албан журмын даатгалаар нэг төлж болно. Сайн дурын даатгуулагчийн хувьд төлж болно гэдэг ийм хоёр үндсэн хэлбэртэй байгаа.

Сайн дурын даатгуулагчийн хувьд өөрийн гэсэн ажил олгогч байхгүй учраас тэтгэврийн даатгалын шимтгэлийг өөрийн зүгээс 11.5 хувиар төлдөг, албан журмын даатгуулагчийн хувьд тэтгэврийн даатгалын шимтгэлд ажил олгогч 8.5, өөрөөсөө 8.5 төлдөг. Ийм харьцаатайгаар эрх үүсэх процесст оролцдог. Ганхуяг гишүүний асуугаад асуугаад байгаа нэг зүйл нь юу вэ гэхээр.../минут дуусав./

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээж хариулаад 5 номер, дахиад 5 номерт 1 минут нэмж өгье. Гүйцээгээд хариул.

Б.Батжаргал: Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх хуулийн дагуу улсад огт ажил хийгээгүй хүмүүсийг 1990-2000 оны хооронд 610 мянган хүнийг хамруулснаас энэ бас тэгш бус байдал гарсан. Энийг бол шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын багц хуулиар Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нөхөн даатгал гэдэг зүйлийг бас хуулиар хориглож өгсөн байгаа.

Тэгэхгүй бол энэ огт ажил хийгээгүй хүмүүс гэнэт нөхөн даатгалд хамрагдаад жилтэй болоод 550, бас ажлаа хийгээд явж байсан улсууд шимтгэлээ төлөөд 550 үүсэхээр энэ шударга бус байдал гараад байгаа нь бас үнэн. Энийг бол шинэ хуулиар хориглосон байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Саяын тэр таны хариулж байгаа хариултаас нэг юм ойлгогдлоо тийм үү? Ингэж ойлголоо шүү. Өмнө нь гарсан бид нарын хууль, зохицуулалтаас болоод гарсан тэр үр дагавар л өнөөдөр тэр шударга бус байна гэдэг асуудал үүсгээд байгаа болохоос биш, өнөөгийн сүүлийн хэдэн жилд энэ нийгэм бодлогын талаар, нийгэм бодлого энэ халамжийн тэтгэврийн талаар гарч байгаа бодлогууд бол ямар нэгэн тийм тэгш бус байдал үүсэх, ийм маргаан мэтгэлцээн үүсгэхээр ийм үр дагавар

гаргахгүй, цэгцтэй байгаа юм гэж ойлголоо тийм үү?

Ингээд Аубакир гишүүн асуултаа асууя. Булгантуяа сайд та гүйцээж хариулах уу? Булгантуяа сайдын микрофоныг нээе дээ.

Х.Булгантуяа: Энэ хууль 2012 онд батлагдсан. Тэтгэврийн шимтгэлийг нь нөхөж төлөх энэ хуулийн зохицуулалтыг хийсэн. Энэ хуулиар яасан бэ гэхээр нийтдээ 60 орчим мянган хүмүүс тухайн үед 38 орчим тэрбум төгрөг төвлөрүүлээд, сүүлийн 11 жилийг тээ Батжаргал дарга, 11 жилийг худалдаж авсан шимтгэлээ төлөөд нэг удаа. Тэгэхдээ ингээд энэ хүмүүс тэтгэврээ одоо ингээд авч байна. Төлсөн хүмүүсээс тал орчим тэтгэвэр тогтоолгоод авсан байна. Нийтдээ 1.5, бараг 2 их наяд төгрөгийг авсан.

Тэгэхээр нөхөн төлөх гэдэг хуулиуд ийм үр дагавартай байдаг. 38 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд, одоо 1.5, бараг 2 их наяд төгрөг үргэлжлүүлээд хэдэн их наяд төгрөг хүртэл л тэтгэврээ авах юм байгаа юм бүү мэд. Тэр хэмжээнд хүртэл авна гэсэн үг.

Дээрээс нь нэмээд Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль гээд хууль 2016 онд баталсан. Энэ хуулиар бас нөхөн төлөөд, тэтгэврээ тогтоолгоод ингээд авч байна. Энийг нуу.../минут дуусав./

Ц.Цэрэнпунцаг: Булгантуяа сайдад дахиад 1 минут нэмээд өгчихье. Та товчхон, тодорхой яриарай.

Х.Булгантуяа: Ингээд энэ Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийг нууц, төрийн нууцад авчихсан. Хэчнээн хүн, хэр их тэтгэвэр авсныг одоо тоон мэдээлэл бид нарт байхгүй. Ил тод болгох юм бол энэ чинь 10 сая төгрөгийн торгуультай билүү. Ийм хууль, эрх зүйн орчин хийгээд, дандаа нөхөн төлөлтүүдийг бий болгосон. Тэтгэврийн

сан хэрвээ яг хууль, журмынхаа дагуу ингэж хууль, журамгүйгээр нэмдэг, нөхөн төлдөг, хэн нэгэнд арай илүү давуу байдал олгодоггүй байсан бол энэ шударгаар явсан бол хүмүүс дуртай байна.

Яагаад гэвэл түрүүний хэлсэнчлэн бид нар 25 жил шимтгэлээ төлөөд, 20 гаруй жил ядаж бид нар эрх зүйн нийгмийн баталгаагаа хангаж байгаа юм. Бид нар өнөөдөр шимтгэл төлөхдөө ажил олгогч, ажилтан нийлээд 2 талаасаа их цалин бол их цалин, бага цалин бол бага цалингаасаа 24 хувийг төлж байна.

Буцаад авахдаа хамгийн өндөр 5 жилээ бид хувь сонгоод 45 хувиар авч байгаа, 45 хувиар. Тэгэхээр мэдээж нөгөө талдаа энэ харах юм бол бид нар нийгмийн баталгааг хангахын төлөө, иргэдийнхээ нийгмийн баталгааг хангахын төлөө.../минут дуусав./

Ц.Цэрэнпунцаг: Манай Булгантуяа сайд ерөөсөө ярих юм их байгаа. Хугацаа бага байгаа учраас багтахгүй байна. Ерөнхийдөө нэг юм бид нар бас ойлгох ёстой юм шиг байна. Гишүүд та бүхэн анхдагч хууль ингэж барьж оруулж ирж байгаа учраас цаашидаа ийм сөрөг үр дагавартай юмнууд гарч ирэхээс болгоомжлоорой гэдэг агуулгаар гишүүд маань асуултаа асууж байгаа байх гэж ойлгож байна. Тэгээд та бүхэн энэ хууль дээр ажиллахдаа хамгийн гол нь бид нар энэ өмнө, сая сайд дахин дахин хэлээд байна шүү дээ бид нар энэ өмнөх алдаануудаа засна гээд нөхөн олговор хэлбэрээр. Араас нь нөхөж гүйцээж ингэж зохицуулалт хийх гэдэг, хууль гаргадаг асуудлууд ийм хүндрэлтэй ийм байдал бий болгож байна гээд тэгж байна. Энэ дээрээ анхаарч, ер нь цаашидаа та бүхэн бас ажиллах биз дээ. Аубакир гишүүн та асуулт асуух уу?

Т.Аубакир: Баярлалаа. Энэ орж ирж байгаа хуулийг бол дэмжиж байгаа юм. Манай улсын хэмжээнд энэ

хүндрэлтэй болчихсон байсан тэтгэврийн санг энэ тэтгэврийн тогтолцоог тодорхой хэмжээнд цэгцлэх ийм зорилго бүхий хууль, зохицуулалт орж ирж байна гэж ойлгож байгаа. Ганц, хоёр асуулт байгаа юм. Энэ нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших энэ хувийн тэтгэврийн сангийн нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших дээд хэмжээг хэдээр тогтоохоор харж байгаа вэ? Энэ бас л онцгой анхаарах ёстой зохицуулалтын нэг нь яах аргагүй мөн. Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт маань хувь тэр тэтгэвэр эзэмшигч маань нас барсан тохиолдолд яг энэ хуулиараа гэр бүлийн хүн нь нас барлаа гэхэд нөгөө хүн нь үлдсэн хүн нь энийг өвлөөд авах, авч үлдэх зохицуулалт нь яг яаж явж байгаа вэ, хэдэн хувийг нь өвлөж авах юм, хэдэн жил тэрийг цаашид аваад явах юм? Энийг яг нарийн зохицуулсан зохицуулалт бий юү? Хоёр дахь асуулт маань.

Гуравдугаар асуулт маань энэ хувийн тэтгэврийн сангийн цаашидын ирээдүйд инфляцын өөрчлөлтийг яг яаж зохицуулахаар орж ирсэн юм бол? Энэ тухайн захиргааны байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хорооноос, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу инфляцтай уялдуулж зохицуулах юм уу? Энийгээ бид нар энэ хууль дээр маш сайн, болгоомжтой зохицуулалт оруулж өгөхгүй бол 5, 10, 20 жилийн дараа магадгүй инфляц яаж өөрчлөгдөөд байлаа. Ингээд нөгөө 5, 10 жилийн өмнө ажил хийсэн хүний маань авах ёстой нөгөө тэтгэвэр маань инфляцад идэгдчихсэн ийм болчихсон байх юм биш биз дээ гэсэн гурав дахь асуулт.

Дөрөвдүгээр асуулт маань энэ хуучин энэ тэтгэврийн сантай холбоотой “Капитал” болон “Чингис хаан” банкны үлдэгдэл яг ямар хэмжээнд ер нь явж байгаа вэ. Энийг манай сайд хариулж өгөх үү, ажлын хэсэг маань хариулах уу гэсэн ийм 4 асуулт байна. Хуулийг бол дэмжиж байгаа. Манай Монгол Улсын тэтгэврийн сангийн

тэтгэврийн энэ тогтолцоонд реформ хийх зайлиггүй шаардлага бий болчихсон, инфляцад идэгдсэн. Сая энэ өнгөрсөн энэ хаврын чуулган, намрын чуулган дамнаад үндсэндээ Монгол Улсын Их Хурал энэ тэтгэврийн тогтолцоог тодорхой хэмжээнд сайжруулах, салбарын яам нь энэ тогтолцоогоо сайжруулахын хүрээнд чамгүй ажлууд хийсэн. Одоо цоо шинэ зохицуулалт орж ирж байгаа юм, Хувь хувийн тэтгэврийн сан гэж тиймээ? Энэ саяын миний энэ 4 асуулт дээр хариулт авъя гэж.

Ц.Цэрэнпунцаг: Аубакир гишүүний асуултад ажлын хэсгийн 5 номер хариулъя.

Б.Батжаргал: Аубакир гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Батжаргал. Хуулийн төсөлд дурдсанаар хувийн тэтгэврийн сан Компанийн тухай хуулиар байгуулагдах ХХК хэлбэрийн компани байх юм. Тэгэхээр Компанийн тухай хуулиар тухайн үүсгэн байгуулагч нь 1 байж болно, 2 байж болох тийм нээлттэй зохицуулалттай оруулсан байгаа.

Хоёр дахь асуултын хувьд нас барвал өвлөгдөх үү гэдэг асуулт байгаа. Энэ хуулийн гол амин сүнс бол өвлөлтийн асуудал байгаа. Яагаад гэвэл энэ мөнгө бол яг тухайн хүн болгоны дансан дээр бодитоор мөнгө хадгалагдаж явна. Тухайн эзэмшигч нь нас барах юм бол эрх залгамжлагч, эсвэл өвлөгч энэ мөнгийг нь өвлөж цаашаа авч үргэлжлүүлнэ.

Гурав дахь асуудал бол хувийн тэтгэврийн сангийн ирээдүйд инфляцын өөрчлөлтийг яаж зохицуулсан бэ гэхээр энэ бол энэ хөрөнгийг итгэмжлэн удирдах хөрөнгө оруулалтын менежментийн компани гэж ажиллахыг хуулиар тусгаж өгсөн байгаа. Тэгэхээр энэ мөнгө бол сул зогсоод байх ёсгүй, байнга эргэлтэд орох ёстой. Хуулийн төсөлд зааснаар бас баталгаат өгөөжийг заавал өгнө гэж заасан хуулийн төсөлд. Баталгаат өгөөжийн хэмжээ

бол Монголбанкны бодлогын хүүгээс багагүй байна, түүнээс дээшээ өгнө гэсэн ийм заалтыг тусгаж оруулсан байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Хоёр асуултад хариуллаа. 3 дахь, 4 дэхэд нь Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Энэ “Капитал” банкны үлдэгдэл “Чингис хаан” банкны үлдэгдэл бас их байгаа. Бид нар энэ асуудлаар Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд бас мэдээлэл хийсэн. Одоо “Капитал” банкны авлага гэхэд үлдэгдэл нь 68.5 тэрбум төгрөг байна. Бид нар эндээс 25 тэрбум төгрөгийн хөрөнгө хүлээн авсан. Сүүлдээ одоо Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл бараг нэг ийм үл хөдлөх хөрөнгийн менежментийн компани шиг зарж борлуулдаг компани шиг юм болж байна. Бид нар аж ахуйн энэ үл хөдлөх хөрөнгө зарж, борлуулдаг компаниудтай хүртэл гэрээ байгуулж, зарж борлуулах ажлуудыг нь бас хийлгэж байна. Энэ бол үнэхээр хэцүү байна.

Дээрээс нь нэмээд энэ “Чингис хаан” банкин дээр гэхэд 94 тэрбум төгрөгийн авлагатай байна. Эдгээр авлагуудыг барагдуулах дээр эрх хүлээн авагчтай Монголбанкнаас байсан эрх хүлээн авагчтай манай Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл гээд бүгдээрээ ажиллаж байгаа ч гэсэн бас Эдийн засгийн байнгын хорооноос хүсэхэд ассет менежментийн ийм компани, хөрөнгийн ийм менежмент хийдэг компани ялангуяа ийм үл хөдлөх хөрөнгүүдийг зарж борлуулдаг, үүн дээр төрийн өмнөөс ажиллаж өгдөг ийм бүтэц их чухал байгаад байна.

Бид нар хамаагүй хувийн хэвшилд байдаг байсан бол жишээлбэл хууль, эрх зүйн хувьд ийм бэлэн хувийн хэвшил байдаг бол бид нар гэрээлээд энэ ажлыг хийлгэмээр байна. Төрийн захиргааны хэдэн албан хаагчид энэ олон үл хөдлөх

хөрөнгүүдийг хүлээж аваад л бид нар Авлигатай тэмцэх газраас, дээрээс нь манайд Монголбанкнаас зааж өгсөн хөрөнгийн үнэлгээний компаниар хөрөнгийн үнэлгээг нь хийлгээд л өнөөдрийг хүлээгээд авсан юм байна лээ. Тэгэхээр ингээд л хүлээж аваад л, зарж борлуулах гээд л ингээд л явж байна гэдэг үнэхээр төвөгтэй байна. Энэ бас том эдийн засгийн том харилцаа. Эдийн засгийн байнгын хорооноос хүсэхэд ийм хууль, эрх зүйн орчныг бий болгож бас өгөөч. Энэ бас өмнө нь бас нэлээдгүй яригдаж байсан юм банкнууд дээр ийм бас юу үүсэж байна. Үүнийг мэргэжлийн тусгайлсан компаниар хийлгэмээр байна гэдэг. Нийтдээ манайх 170 орчим тэрбум төгрөгийн авлага бол байна “Капитал” банк, “Чингис хаан” банк хоёр дээрээс.

Ц.Цэрэнпунцаг: Асуулт юу байлаа Аубакир гишүүнээ. Больчихсон уу хариулт хангалттай байна уу? Тодруулж асууя Аубакир гишүүний микрофоныг нээе.

Т.Аубакир: Би ажлын хэсгээс аягүй тодорхой асуулт асуусан л даа. Энэ Компанийн тухай хуулийг би сайн мэднэ, хэчнээн ч хувьцаа эзэмшигчтэй байж болно. Би нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших хувь хэдэн хувь юм бэ л гээд байгаа шүү дээ. Нэг хүн дээр эсвэл тэр сангийнх нь 50 хувь нь байж болох юм уу, 60 хувь нь юм уу, эсвэл 10 хүртэл хувийг нь энэ Засгийн газрын хуралдаан дээр бас хэмжээг юунд үндэслэн тогтоогдсон нь хуулийн төслийн тандан судалгаанаас харагдахгүй байна гээд Засгийн газрын хуралдаан дээр хэлсэн байна шүү дээ. Нэг хүнд Аубакир гэдэг хүн тэр сангийн 50 хувийг эзэмшиж болох юм уу? Энэ чинь өөрөө эргээд нөгөө сандаа тэр тогтолцоондоо сөрөг нөлөөлөөд нэг хүнд хэтэрхий их хувийг өгснөөс гэж асууж байгаа юм. Нэг хүн, нэг хувьцаа эзэмшигч нь хэд хүртэл хувь эзэмших юм бэ гэж. Нас барсан тохиолдолд бас тодорхой асуулт асуусан. Ажлын хэсэг над руу хар даа, анхаарахгүй сууж байгаад асуултад буруу хариулаад байх шиг байна уучлаарай. Хэдэн хувь нь хэдэн жилээр

өвлөгдөх юм? Эмгэн, өвгөн хоёр байж байгаад өвгөн нас барчихлаа гэхэд эмгэн нь хэдэн хувийг нь хэдэн жил аваад явах юм, 20 жил, 30 жил, 2 жил? Яг энэ тодорхой саяын хоёр асуултад тодруулчихъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 5 номер хариулъя.

Б.Батжаргал: Гишүүний тодруулгууд дахиад тодруулгыг өгье. Өвлөлтийн асуудал тэтгэврийн төрлөөсөө бас хамаарч байгаа гишүүнээ. Энэ дээр тэр хуулийн төсөл дээр 3 төрлийн байдлаараа тэтгэврээ авч болно буцаагаад.

Нэгдүгээрт бөөндөө нийт дүнгээрээ хуримтлалаа нэгдүгээрт авч болно.

Хоёрдугаарт хуваарьт тэтгэвэр 10 хүртэл жил хувааж авч болно.

Гуравдугаарт насан туршийн тэтгэвэр буюу амьдралынхаа туршид хувааж авч болно гэсэн ийм гурван төрлийн тэтгэвэр байгаа.

Тэгэхээр энэ гурван төрлийн тэтгэврийг сонгоод явж байсан төрлөөсөө хараад нэг удаа бөөндөө авчихсан хүний хувьд үлдэгдэл байхгүй, өвлөгдөх мөнгө байхгүй.

Хуваарьт тэтгэвэр болон насан туршийн тэтгэвэр авч байгаа хүмүүсийн хувьд үлдэгдлийг нь тооцож гаргаад, тэр үлдэгдэл нь хэдэн төгрөг байгаа юм бэ, энэ үлдэгдлийг хүн болгон дээр өөр байх учраас хувь бас хэлэхэд бас хэцүү байгаа. Ямар хугацаанд авсан юм, хэдэн төгрөг анх хуримтлуулсан юм, хэдийг бас авчхаад байгаа юм гэдэг дээр хүн болгон дээр кэйс өөр учраас одоо энэ дээр хувь бас гарахад хэцүү байгаа. Үлдэгдэл гэсэн агуулгаар нь оруулсан байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Дахиад ажлын хэсгийн 5 номер дахиад 1 минут өгье. Гүйцээгээд хариулаадахъя.

Б.Батжаргал: За тийм, хуваарьт тэтгэвэр болон насан туршийн тэтгэвэр авахад тэр бол нас бараагүй байх үедээ авч байх үед бол татвар бол авахгүй. Тухайн хуваарьт болон насан туршийн тэтгэврийг өвлөж аваад нэг удаа бөөндөө авсан тохиолдолд энэ дээр татвар ноогдуулна. Харин буцаагаад өөрийнхөө хуримтлал дээрээ нэмээд, буцаад тэр нөгөө хуваарьт насан туршийн тэтгэврээ буцаагаад аваад эхлэх юм бол татвар бас ноогдуулахгүй хөнгөлнө гэсэн ийм заалт бас орсон байгаа. Яагаад гэвэл аль болох амьжиргааг дэмжих зориулалттай байгаа.

Нэг хувьцаа эзэмшигч яг хэдэн хувь эзэмших вэ гэдэг дээр яг хуулийн төсөл дээр тодорхой оруулаагүй. Хоёр хүн нийлж байгууллаа гэх юм бол тэр 60:40-өөр хөрөнгөө оруулж болно, 50:50 байж болно. Тэр үүсгэн байгуулагчийн гэрчилгээ, дүрэм дээрээ энэ заалтаа тодорхой оруулж өгөхөөр Компанийн тухай хуулийн зохицуулалтаар оруулж байгаа. Гэхдээ энэ заалтыг манай дэд ажлын хэсэг дээр бас эргээд бид нар бас ярьж байгаа. Тийм, тодорхой болгохоор. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Аубакир гишүүн хариулт хангалтгүй учраас нэмж асуулт асууя гэж байна. Микрофоныг нь.

Т.Аубакир: Нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших хувийг маш хатуу тогтоож өгөхгүй бол Булгантуяа сайд аа, манай хууль санаачлагчид маань, Булгантуяа сайд аа нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших хувийг маш тодорхой тогтоож өгөхгүй бол энэ манайд болсон тохиолдлууд бий шүү дээ энэ хадгаламж, зээлийн хоршоод дампуурсан. Хувь хүн итгээд, сонгоод тэр хувийн тэтгэврийн санд төлөөд яваад байсан чинь тэр нөгөө сан нь дампуурчих юм бол тийм ээ. Тийм учраас энэ нэг хүний эзэмших хувийг маш хатуу тогтоож өгөх ёстой. Манай ажлын хэсэг маань энийг бас анхаараарай. Энэ

зүгээр ингээд л итгээд орхичхож болох зүйл биш шүү. Эргээд энэ татвар төлөгчдийн бүр яг үндсэн язгуур эрх ашиг байж байгаа учраас энэ дээр маш анхааралтай явах ёстой юм байгаа юм.

Хоёрдугаарт тэр нас барсан иргэдийн нөгөө өвлөх асуудал дээр мөн л яг л хатуу тогтоож өгөхгүй бол хүн болгоны кэйс өөр шүү дээ гээд эсвэл тэгвэл яаман дээр очоод ч юм уу тэр тэтгэврийн сан дээр нь очоод хүн наймаацах юм уу эсвэл яах юм? Энэ чинь аягүй тодорхой биш байгаа байхгүй юу. Одоо энэ.../минут дуусав./

Ц.Цэрэнпунцаг: Тийм тийм. Ер нь энэ Аубакир гишүүний хэлээд байгаа тэр сүүлийн ялангуяа тэр нарийн яг процедурыг нь бичиж өгөхгүй бол баахан маргааны эх үүсвэр болно шүү. Баахан гомдогсод гарч ирнэ. Бараг тэнд наад байцаагч нар тийм үү нэг төрийн албан хаагчдын эрх мэдлийн асуудал болоод ингээд тэд нар тэр эрх мэдлээ санамсартай болон санамсаргүй, мэдээд болон мэдэхгүйгээр зөрчиж ард иргэдийг бухимдуулдаг ийм юм болоод явчихвал хүндрэл гарна шүү гээд байгаа энэ дээр бас анхаараарай. Та бүхэн энэ хууль нь энэ цаашаа хэлэлцэх эсэх нь шийдэгдээд явчих юм бол ажлын хэсэг дээрээ энэ дээр сайн анхаарч ажиллаарай. Саяын асуудлууд их чухал шүү.

Дээрээс нь сая Булгантуяа гишүүний тэр яриад байгаа энэ 2 банкин дээр баахан мөнгөө алдчихсан, одоо тэгээд тэрнийхээ оронд бараг л ширээ, сандал авчихсан юм шиг юм яриад байна заримд нь. Энийгээ яаж борлуулах вэ гээд. Энэ асуудал чинь яг энэ түрүүн энэ Булгантуяа сайд та энэ Эдийн засгийн байнгын хороонд байхад бид нар санаж байгаа биз дээ Активын удирдлагын компани байгуулъя гээд тийм үү, актив удирдлагын компани гэж байгуулъя гээд орж ирж хэлэлцэх энэ яриа явагдаад, тэгээд энэ чинь гишүүд нэлээн эсэргүүцсэн. Яагаад вэ гэхээр зэрэг энэ банкин дээр байж байгаа баахан энэ чанаргүй зээлүүдээ энэ. Харин тийм,

энийг бид нар харин тийм гарцыг нь бол яг яригдаагүй биш, яригдаж байсан асуудал. Тэгэхдээ энэ ингээд гацсан, мухардалд ороод ингээд нам зогсчихсон юм. Тэгээд энэ асуудал дахиж чухам аль шатдаа явж байгаа юм. Ийм байна.

Энэ Ганхуяг гишүүнээ одоо бид нар чинь санал, дүгнэлтээ Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлнэ Булгантуяа сайдаа тийм үү. Ажлын хэсэг байгуулахдаа наашаа, харин тийм.

Энэ 5 дахь өдрийн Даргын дэргэдэх зөвлөл дээр би яриад Байнгын хороон дээр татаж авах асуудлаа ярья. Манай Эдийн засгийн байнгын хорооны гишүүд бас нэлээн эдийн засгийнх нь агуулга талаас нь харж бас ач холбогдол өгч ер нь авч энэ дээрээ ажиллала гэж байгаа учраас Эдийн засгийн байнгын хороон дээрээ байх нь зүй зүйтэй гэж үзэж байгаа. Сайд ч гэлээ тэгж үзэж байгаа гэж би ойлгож байгаа. Тэгэхээр Даргын дэргэдэх зөвлөл дээр би санал гаргая. Ингээд дэмжигдэх юм бол энэ ажлын хэсэг энэ анхдагч хуулийг Байнгын хороон дээрээ авах ажил ярья. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Засгийн газрын өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье. Гарвал хураана шүү дээ. Ингээд зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

1.1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна

1.2.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй санал энэ хууль дээр ирээгүй байна

1.3.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй саналууд энэ хууль дээр ирээгүй байна

1.4.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй саналууд ирээгүй байна.

1.5.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн нь Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй санал араагүй байна.

1.6.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн

мэдүүлсэн нь Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна

1.7.Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл хэсэг заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

2.Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна .

Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан

зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж эхэлье.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай, Тэтгэврийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлэх санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Нийгмийн бодлогын байнгын хороонд уншиж танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

15.29 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР